



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны III улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт.....	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт.....	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт.....	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт.....	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт.....	8
Статистик үзүүлэлтүүд.....	9
Харилцагчид, зээлдэгчид.....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид.....	9
Тархалт.....	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
Хөрөнгө оруулалт.....	13
Зээл.....	13
Цахим зээл	16
Ногоон зээл	18
Факторингийн тооцооны авлага.....	20
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	20
Санхүүгийн бус хөрөнгө.....	21
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	22
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	23
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	24
Бусад эх үүсвэр.....	25
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	25
Төслийн зээлийн санхүүжилт.....	26
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ).....	26
Бусад санхүүгийн өр төлбөр.....	26
Санхүүгийн бус өр төлбөр.....	26
Өөрийн хөрөнгө.....	27
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	27
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг.....	28
Хуримтлагдсан ашиг.....	29
Ашигт ажиллагаа.....	30
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	31
Дүгнэлт.....	32
Актив, пассивын бүтэц.....	33
Ашигт ажиллагаа.....	33
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	34

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр).....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	11
Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр).....	12
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)	13
Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр).....	13
Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)	15
Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)	16
Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)	16
Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр).....	17
Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)	18
Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)	20
Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)	20
Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	21
Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	22
Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)	24
Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)	24
Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)	25
Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)	26
Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)	26
Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр).....	27
Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	27
Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	27
Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр).....	28
Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр).....	28
Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)	30
Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр).....	30
Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр).....	31
Хүснэгт 37 2025 оны III улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр).....	32

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	12
Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)	14
Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)	14
Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)	15
Зураг 7 Сүүлийн 5 жилийн байдлаар финтек зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)	16
Зураг 8 Сүүлийн 3 жилийн байдлаар ногоон зээлийн үлдэгдэл(тэрбум төгрөгөөр).....	19
Зураг 9 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)	19
Зураг 10 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	22
Зураг 11 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	23
Зураг 12 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)	23
Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	25
Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар	26
Зураг 15 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 16 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	29
Зураг 17 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	29
Зураг 18 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр).....	30
Зураг 19 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр	32

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
СТ	Санхүүгийн тайлан
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ЗМС	Зээлийн мэдээллийн сан

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2025 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 577 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 22 ББСБ буюу 4.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 97 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2021-III	2022-III	2023-III	2024-III	2025-III
Шинээр олгосон	9	14	18	39	11
Хүчингүй	10	26	10	13	7
Түдгэлзүүлсэн	20	57	12	20	27
Сэргээсэн	6	19	17	14	5
Нийт ББСБ	531	522	521	555	577
Үүнээс: ХОН	83	93	95	97	97
Үүнээс: ГХО	28	26	24	28	27
Салбар	331	427	446	521	570
Төлөөлөгч	8	8	11	12	10

2025 оны III улирлын байдлаар 11 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 27 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 5 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээж, 7 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2025 оны III улирлын байдлаар 72 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2024-III	2025-III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	6,417.6	8,529.3	32.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	10.2%	11.3%	1.1%
Нийт өөрийн хөрөнгө	3,379.3	4,607.7	36.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	52.1%	61.4%	9.3%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,714.9	2,110.7	23.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	99.4%	116.2%	16.8%
Нийт зээл	5,198.2	6,968.4	34.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	14.6%	16.0%	1.4%
Нийт орлого	1,282.6	1,941.1	51.3%
Нийт зарлага	783.3	1,223.6	56.2%
Цэвэр ашиг	499.3	717.5	43.7%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар өсөж, банкны салбарын 11.3%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 116.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.8 пунктээр өссөн дүн юм.

2025 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр өсөж 8.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 83.8 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 58.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 51.3 хувиар буюу 658.5 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 56.2 хувиар буюу 440.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 43.7 хувиар буюу 218.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2024-III	2025-III	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	555	577	22	4.0%
1	Зээл	492	511	19	3.9%
	Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг	297	320	23	7.7%
2	Факторингийн үйлчилгээ	63	60	-3	(4.8%)
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	30	2	7.1%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	7	1	16.7%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	53	55	2	3.8%
6	Гадаад валютын арилжаа	176	169	-7	(4.0%)
	Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг	60	63	3	5.0%
7	Итгэлцлийн үйлчилгээ	90	90	-	-
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	43	55	12	27.9%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 577 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 88.6% нь буюу 511 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 55.5% нь буюу 320 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 169 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 29.3 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 63 ББСБ нийт ББСБ-уудын 10.9 хувийг бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оноос 19 ББСБ-аар буюу 3.9 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа 2 ББСБ-аар буюу 7.1 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 12 ББСБ-аар буюу 27.9 хувиар, цахим

төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 2 ББСБ-аар буюу 3.8 хувиар өссөн бол факторингийн үйлчилгээ 3 ББСБ-аар буюу 4.8 хувиар, гадаад валютын арилжаа 7 ББСБ-аар буюу 4.0 хувиар, тус тус буурсан байна.

2025 оны III улирлын тайлан мэдээний ирц 97.1% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 577 ББСБ-аас 560 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 11 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмаар банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын хувьд итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 60 хувиас хэтрэхгүй байх, нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ хоёроос дээш хувь бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 65-80 хувь хүртэл байх, бусдаас өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-ын хувьд гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 30 хувиас хэтрэхгүй байх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан ББСБ-ын хувьд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлэх дүн нь өөрийн хөрөнгийн 60 хувиас хэтрэхгүй байх, мөн ББСБ нь дотоодын арилжааны банк, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байхаар зохицуулсан.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”, 78 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журмын өөрчлөлтийн хүрээнд ББСБ-аас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар, суудлын автомашин барьцаалсан зээл, зээл үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус өөрчлөлт оруулсан.

3. 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр тусгай зөвшөөрөлтэй нийт 300 гаруй ББСБ-д Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ буюу нэмэлт, өөрчлөлт орсон журмуудын талаар танилцуулах сургалт зохион байгуулсан.

4. Санхүүгийн зохицуулах хороо Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран салбарын эрх зүйн орчинд гарсан өөрчлөлттэй холбогдуулан ББСБ-уудын удирдлагуудад зориулсан “Банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх захирал мэргэшүүлэх сургалт”-ыг 2025 оны 9-р сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

5. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын эрх зүйн орчны шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 264 дүгээр захирамжаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгийн анхдугаар хурлыг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2025 оны III улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 94.2 хувь буюу 540 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 90.4 хувь буюу 518 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

2025 оны III улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 511 ББСБ-ын 95.9 хувь буюу 490 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 100 ББСБ, 19,487 удаагийн тохиолдлоор, 2,057.6 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 12 ББСБ, 5,554 удаагийн тохиолдлоор, 38.2 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-д тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2025 оны III улирлын байдлаар нийт 576 ББСБ-аас 1,469.5 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 97.8% буюу 564 ББСБ 1,456.0 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2025 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 38,583 хувьцаа эзэмшигчдийн 577 ББСБ, 570 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,519 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.6 сая харилцагч, 2.8 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар буурч давхардсан тоогоор 3,732,579, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 42.1 хувиар өсөж 2,829,184-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дун	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	3,732,579	2,864,218	344,484	3,388,095	81,221	3,672,300	60,279	471,454	97,974
Үүнээс: Эмэгтэй	1,948,426	1,484,663	194,023	1,754,403	48,410	1,916,555	31,871	251,518	49,839
Эрэгтэй	1,766,589	1,378,170	134,116	1,633,473	19,017	1,738,266	28,323	219,499	47,636
Хуулийн этгээд	17,564	1,385	16,345	1,219	13,794	17,479	85	437	499
Итгэмжлэгчдийн тоо	14,688	14,681	1,482	13,206	-	14,629	59	6,560	336
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	2,323	2,251	255	2,068	-	2,323	-	607	2
Зээлдэгчдийн тоо	2,829,184	2,206,425	151,058	2,678,126	44	2,774,141	55,043	219,648	97,962
Хэвийн	2,425,190	1,908,222	125,405	2,299,785	19	2,383,801	41,389	170,904	78,753
Хугацаа хэтгэсэн	126,802	96,790	5,984	120,818	-	123,596	3,206	12,857	5,614
Чанаргүй:	277,192	201,413	19,669	257,523	25	266,744	10,448	35,887	13,595
-Хэвийн бус	99,103	73,564	5,215	93,888	4	95,816	3,287	15,654	7,888
-Эргэлзээтэй	92,959	66,831	2,777	90,182	1	89,345	3,614	13,913	4,094
-Муу	85,130	61,018	11,677	73,453	20	81,583	3,547	6,320	1,613
Зээлдэгчдийн насжилт	2,823,562	2,203,785	149,884	2,673,678	2	2,768,599	54,963	219,207	97,479
18-25 насны	522,095	379,262	15,074	507,021	-	512,295	9,800	36,225	14,409
26-35 насны	1,162,949	874,636	45,207	1,117,742	2	1,137,397	25,552	85,358	37,282
36-45 насны	748,117	617,895	50,911	697,206	-	736,012	12,105	62,223	27,964
46-55 насны	316,909	270,234	28,587	288,322	-	311,107	5,802	26,859	12,878
55-аас дээш	73,492	61,758	10,105	63,387	-	71,788	1,704	8,542	4,946
Зээлдэгчдийн боловсрол	2,825,704	2,203,785	149,884	2,675,820	2	2,770,741	54,963	219,207	97,479
-Дээд	1,510,345	1,174,778	71,664	1,438,681	2	1,485,063	25,282	107,566	62,839
-Тусгай дунд	277,464	230,414	8,817	268,647	-	272,337	5,127	33,607	12,905
-Бүрэн дунд	720,766	526,509	45,049	675,717	-	698,562	22,204	62,391	13,450
-Дунд	242,026	206,063	16,589	225,437	-	240,416	1,610	12,712	6,035
-Бага	75,103	66,021	7,765	67,338	-	74,363	740	2,931	2,250

(Финтек ББСБ-ууд цахим, уламжлалт зээл хослуулан олгодог болно)

Нийт харилцагчдын 90.8% буюу 3,388,095, зээлдэгчдийн 94.7% буюу 2,678,126 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж (финтек), онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 9.2% буюу 344,484, зээлдэгчдийн 5.3% буюу 151,058 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 81,221 буюу нийт харилцагчдын 2.2 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)

Үзүүлэлтүүд	2021-III	2022-III	2023-III	2024-III	2025-III	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,666	23,143	28,369	34,174	38,583	4,409	12.9%
Ажилчдын тоо	3,820	4,478	4,909	5,855	6,519	664	11.3%
Харилцагчдын тоо	4,530,126	4,897,575	4,141,367	4,932,619	3,732,579	-1,200,040	-24.3%
Зээлдэгчдийн тоо	1,562,757	1,644,423	1,461,198	1,990,848	2,829,184	838,336	42.1%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	2.6%	3.1%	3.3%	3.4%	3.7%		0.3%

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар буюу 4,409-өөр өсөж 38,583-г хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 97.0 хувь буюу 37,420 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,163 буюу 3.0% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 3,120 буюу 8.1% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байгаа бол 217 буюу 0.6% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна. ББСБ-ын салбарын нийт ажилтнуудын тоо өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар буюу 664 ажилтнаар нэмэгдэж 6,519-д хүрсэн байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	38,583	37,661	1,948	36,635	85	38,366	217	37,439	3,120
Нийт ажилтнуудын тоо	6,519	4,167	2,784	3,735	149	6,221	298	589	508
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	3,917	2,506	1,680	2,237	85	3,708	209	378	333
Эрэгтэй ажилтны тоо	2,602	1,661	1,104	1,498	64	2,513	89	211	175

Хөдөө орон нутгийн 97 ББСБ 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	577	90	500	77	63	480	97	5	572	27
1 Зээл	511	90	434	77	0	419	92	5	506	26
2 Факторингийн үйлчилгээ	60	37	31	29	0	56	4	3	57	1
3 Төлбөрийн баталгаа гаргах	30	16	20	10	0	29	1	3	27	3
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	7	6	0	7	0	7	0	1	6	0
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	55	27	30	25	0	53	2	3	52	2
6 Гадаад валютын арилжаа	169	36	140	29	63	153	16	5	164	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	90	90	49	41	0	86	4	5	85	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	55	34	32	23	0	52	3	3	52	3
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	0	0	1	0	0	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 83.2% буюу 480 ББСБ, салбаруудын 60.0% буюу 342 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 16.8% буюу 97 ББСБ, салбаруудын 40.0% буюу 227 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2025 оны III улирлын байдлаар 120 ББСБ-ын 570 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 55.6 хувийг 14 ББСБ-ын 317 салбар бүрдүүлж байна. Мөн Австрали улсад 1 салбар бүртгэлтэй байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	480	342	822	100.0%
1. Сүхбаатар	159	45	204	24.8%
2. Чингэлтэй	128	32	160	19.5%
3. Баянзүрх	56	85	141	17.2%
4. Баянгол	67	44	111	13.5%
5. Хан-Уул	61	49	110	13.4%
6. Сонгинохайрхан	8	75	83	10.0%
7. Багануур	1	7	8	1.0%
8. Налайх	-	5	5	0.6%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Дархан-Уул, Төв, аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	97	227	324	100%
Архангай аймаг	2	7	9	2.8%
Баян-Өлгий аймаг	3	5	8	2.5%
Баянхонгор аймаг	4	11	15	4.6%
Булган аймаг	2	2	4	1.2%
Говь-Алтай аймаг	1	3	4	1.2%
Говьсүмбэр аймаг	3	4	7	2.2%
Дархан-Уул аймаг	9	22	31	9.6%
Дорноговь аймаг	3	12	15	4.6%
Дорнод аймаг	6	20	26	8.0%
Дундговь аймаг	0	8	8	2.5%
Завхан аймаг	2	7	9	2.8%
Орхон аймаг	9	22	31	9.6%
Өвөрхангай аймаг	10	15	25	7.7%
Өмнөговь аймаг	2	21	23	7.1%
Сүхбаатар аймаг	5	8	13	4.0%
Сэлэнгэ аймаг	9	13	22	6.8%
Төв аймаг	19	9	28	8.6%
Увс аймаг	2	9	11	3.4%
Ховд аймаг	1	8	9	2.8%
Хөвсгөл аймаг	2	10	12	3.7%
Хэнтий аймаг	3	11	14	4.3%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2025 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 8.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.9 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 83.8 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Активын үзүүлэлтүүд	2024-III		2025-III		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,151,577.7	95.9%	8,146,098.3	9.7%	1,994,520.6	32.4%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	726,641.3	11.3%	831,387.8	1.5%	104,746.4	14.4%
Хөрөнгө оруулалт	72,416.4	1.1%	127,289.5	80.4%	54,873.1	75.8%
Зээл (цэврээр)	5,155,519.8	80.3%	6,859,987.3	0.9%	1,704,467.5	33.1%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	17,951.9	0.3%	77,405.4	0.1%	59,453.4	331.2%
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	815.0	0.0%	6,965.6	2.9%	6,150.5	754.6%
Бусад санхүүгийн хөрөнгө	178,233.1	2.8%	243,062.8	4.5%	64,829.6	36.4%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	266,020.7	4.1%	383,234.8	2.0%	117,214.2	44.1%
Санхүүгийн бус бусад хөрөнгө	103,290.1	1.6%	167,034.3	1.9%	63,744.3	61.7%
Үндсэн хөрөнгө (цэврээр)	124,482.8	1.9%	164,054.6	0.6%	39,571.8	31.8%
Биет бус хөрөнгө (цэврээр)	38,247.8	0.6%	52,145.9	9.7%	13,898.1	36.3%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,417,598.3	100.0%	8,529,333.1	100.0%	2,111,734.8	32.9%


2025 оны III улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 11.3 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 16.0 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2020 оны III улиралд 1,942.1 тэрбум төгрөг байсан бол 2025 оны III улирлын байдлаар 4.4 дахин өсөж 8,529.3 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь нийт зээлийн үлдэгдэл 5.1 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын нийт хөрөнгийн 98.4% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 411 ББСБ, 0.6% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 21 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.0 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 145 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	7,634.5	188	89.5%	32.6%	31.9	3	20.4	3	-	-
2.5-5.0 тэрбум	757.9	223	8.9%	38.6%	3.9	1	8.4	2	5.8	2
1.9-2.5 тэрбум	47.7	21	0.6%	3.6%	-	-	8.4	4	2.1	1
1.4-1.9 тэрбум	25.0	15	0.3%	2.6%	6.6	4	6.3	4	5.0	3
0.6-1.4 тэрбум	32.6	36	0.4%	6.2%	9.5	10	15.1	17	6.8	8
0.6 тэрбум хүртэлх	31.5	94	0.4%	16.3%	-	-	14.9	49	17.7	49
НИЙТ	8,529.3	577	100.0%	100.0%	51.8	18	73.4	79	37.4	63

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 5.0 их наяд төгрөг байгаа нь нийт активын 58.3 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 4.2 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 60.0 хувийг бүрдүүлж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 104.7 тэрбум төгрөгөөр буюу 14.4 хувиар өсч 831.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 12.4 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 73.4 хувь нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 14.2 хувь нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 1.4 хувь нь мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	831.4	504.1	386.7	444.7	34.5	812.8	18.6	162.1	146.4
Бэлэн мөнгө	103.4	7.5	95.0	8.4	27.1	97.1	6.3	1.8	2.5
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	610.3	412.2	253.9	356.4	6.8	601.4	8.9	151.1	133.6
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	7.8	5.1	4.7	3.0	0.1	7.8	-	-	2.3
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	109.9	79.2	33.1	76.8	0.6	106.5	3.4	9.2	8.0

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 24.6%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.9%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 78.5% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 75.8 хувиар буюу 54.9 тэрбум төгрөгөөр өсөж, 2025 оны III улирлын байдлаар 48 ББСБ 127.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 1.3 хувь буюу 1.6 тэрбум төгрөг нь хадгаламжийн сертификат, 98.7 хувь буюу 125.7 тэрбум төгрөг нь үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	127,289.5	119,968.1	22,331.1	104,958.4	1.0	125,887.3	1,402.2	54,674.3	43,812.3
Хадгаламжийн сертификат	1,592.2	1,592.2	-	1,592.2	-	1,592.2	-	-	-
Үнэт цаас	125,697.2	118,375.8	22,331.1	103,366.1	1.0	124,295.0	1,402.2	54,674.3	43,812.3
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	76,245.7	71,176.9	18,532.5	57,713.1	1.0	74,843.5	1,402.2	27,102.6	23,602.6
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	23,187.6	22,500.4	1,516.7	21,670.9	-	23,187.6	-	7,428.5	-
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	24,659.5	23,116.6	2,142.8	22,516.6	-	24,659.5	-	19,275.4	19,477.1
Барьцаанд байгаа үнэт цаас	-	-	-	-	-	-	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,604.5	1,581.9	139.0	1,465.5	-	1,604.5	-	867.9	732.5
(Үнэт цаасны эрсдэлийн сан)	-	-	-	-	-	-	-	-	-

2025 оны III улирлын байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөлтэй 55 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 48 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 36 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 34.6 хувь буюу 1.9 их наяд төгрөгөөр өсөж 2025 оны III улирлын байдлаар 7.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 408.3 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 6.9 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	6,859.99	5,245.81	2,365.26	4,494.73	2.24	6,768.36	91.63	1,067.00	768.16
Зээл	7,268.36	5,539.33	2,502.41	4,765.96	2.29	7,170.01	98.36	1,148.23	819.48
Хэвийн	6,019.33	4,631.51	2,082.12	3,937.21	1.82	5,938.10	81.23	936.70	673.84
Анхаарал хандуулах	327.42	256.98	98.94	228.47	-	323.29	4.12	58.79	41.49
Чанаргүй зээл	621.62	451.73	201.85	419.77	0.10	611.57	10.05	110.25	75.83
-Хэвийн бус зээл	222.51	171.23	59.33	163.18	0.06	220.06	2.46	47.89	32.58
-Эргэлзээтэй зээл	199.91	157.02	50.06	149.84	0.00	196.07	3.83	45.46	28.64
-Муу зээл	199.20	123.49	92.45	106.75	0.04	195.44	3.76	16.91	14.61
(ЗЭС)	408.26	293.53	137.03	271.23	0.05	401.53	6.73	81.23	51.31
Хойшлогдсон төлбөр	5.55	5.37	0.78	4.77	-	5.55	-	2.95	2.95
Зээлд хур/тооцсон хүүгийн авлага	305.55	204.48	120.28	185.27	0.38	302.60	2.95	45.44	31.26
ЗЗ-ийн хүүнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	0.12	-	0.12	-	-	0.12	-	-	0.00


(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)

Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа эрхэлдэг нэр бүхий ББСБ-ын 1.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь тус ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2024 оны

03 сарын 20-ны 119 дүгээр тогтоолоор хүчингүй болгосонтой холбоотойгоор тайланд үлдэгдэл хэлбэрээр туссан болно. Тайлант хугацаанд ББСБ-ууд 10.9 их наяд төгрөгийн зээлийг 3.7 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 9.8 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2025 оны III улирлын байдлаар 2.8 сая зээлдэгчийн 7.0 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 86.4 хувийг буюу 6.0 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.7 хувийг буюу 327.4 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.9 хувийг буюу 621.6 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хувь 2.7, анхаарал хандуулах зээлийн хувь 1.0 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 949.0 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 43.0 хувьд буюу 408.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2025 оны III улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 13.6% байна.

Олгосон зээлийн 92.8 хувь буюу 10.1 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 7.2 хувь буюу 785.8 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 93.7 хувь буюу 9.2 их

наяд төгрөг нь иргэдээс, 6.3 хувь нь буюу 618.3 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

2025 оны III улирлын байдлаар 7.0 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба үүний 89.3 хувь буюу 6.2 их наяд төгрөгийг иргэдийн, 10.7 хувь буюу 748.5 тэрбум төгрөгийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	46,478.9	0.4%	35,226.1	0.4%	76,800.8	1.1%
2.	Уул уурхай, олборлолт	51,973.8	0.5%	49,098.0	0.5%	86,397.1	1.2%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	57,863.2	0.5%	39,118.5	0.4%	69,811.1	1.0%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	10,816.1	0.1%	6,161.6	0.1%	14,303.8	0.2%
5.	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	4,746.4	0.0%	4,175.8	0.0%	6,234.0	0.1%
6.	Барилга	251,117.7	2.3%	234,173.1	2.4%	332,239.2	4.8%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	700,898.0	6.4%	650,908.1	6.7%	740,293.0	10.6%
8.	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	215,299.9	2.0%	181,719.3	1.9%	241,202.2	3.5%
9.	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	78,628.4	0.7%	78,410.5	0.8%	119,913.9	1.7%
10.	Мэдээлэл, холбоо	17,490.7	0.2%	19,807.2	0.2%	34,415.8	0.5%
11.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	188,043.2	1.7%	137,767.5	1.4%	123,016.5	1.8%
12.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	137,431.4	1.3%	110,884.9	1.1%	92,588.2	1.3%
13.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6,499.9	0.1%	7,730.3	0.1%	9,684.0	0.1%
14.	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	12,305.2	0.1%	13,440.5	0.1%	19,886.6	0.3%
15.	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	7,373.6	0.1%	8,333.8	0.1%	12,091.0	0.2%
16.	Боловсрол	43,761.8	0.4%	34,673.4	0.4%	40,388.5	0.6%
17.	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	21,899.6	0.2%	17,410.3	0.2%	31,076.1	0.4%
18.	Урлаг, үзвэр, тоглоом наадам	8,419.4	0.1%	3,544.0	0.0%	10,674.8	0.2%
19.	Бусад	9,069,202.3	83.0%	8,155,136.5	83.3%	4,907,346.3	70.4%
<i>Иргэнд олгосон зээл</i>		10,144.4	92.8%	9,169.5	93.7%	6,219.9	89.3%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		785.8	7.2%	618.3	6.3%	748.5	10.7%
НИЙТ		10,930,249.6	100%	9,787,719.5	100%	6,968,362.9	100%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “[Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал](#)”-аар нийт олгосон зээлийн 83.0% буюу 9.1 их наяд төгрөг нь бусад ангилалд (ихэвчлэн хэрэглээний зээл), 6.4% буюу 700.9 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 83.3% буюу 8.2 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 6.7% буюу 650.9 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс төлөгджээ.

Тайлант улиралд олгосон зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 26.8 хувийг, 1-3 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 13.0 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 19.8 хувийг, 1-5 жил хүртэлх хугацаатай олгосон зээл тус тус нийт зээлийн 29.4 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 7.0 их наяд төгрөгийн зээлийн 55.2 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 22.7 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 9.3 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	10,144.4	92.8%	9,169.5	93.7%	6,219.9	89.3%
Хэрэглээнд зориулсан зээл	7,042.6	64.4%	6,709.9	68.6%	3,846.8	55.2%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	886.5	8.1%	854.0	8.7%	1,585.0	22.7%
Бизнес зориулсан зээл	1,442.0	13.2%	1,072.0	11.0%	1,364.0	19.6%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	108.8	1.0%	89.2	0.9%	176.8	2.5%
Бусад зээл	1,551.0	14.2%	1,298.4	13.3%	832.3	11.9%
Хуулийн этгээдэд олгосон зээл	785.8	7.2%	618.3	6.3%	748.5	10.7%
Бизнесийн зээл	624.5	5.7%	483.2	4.9%	644.9	9.3%
Автомашинны зээл	4.2	0.0%	6.5	0.1%	10.2	0.1%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	22.1	0.2%	19.8	0.2%	11.4	0.2%
Бусад зээл	135.0	1.2%	108.8	1.1%	81.9	1.1%
НИЙТ	10,930.2	100%	9,787.7	100%	6,968.4	100%

Цахим зээл


Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 77 ББСБ 72 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	4,878,050,968.2	70.0%	192,073	6.8%	25,396.9
Цахим зээл	2,090,311,967.1	30.0%	2,637,111	93.2%	792.7
Нийт	6,968,362,935.3	100.0%	2,829,184	100.0%	2,463.0

2025 оны III улирлын байдлаар ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 2.6 сая зээлдэгчийн 2.1 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 93.2 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 30.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 792.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 32.0 дахин бага байна.

Зураг 7 Сүүлийн 5 жилийн байдлаар финтек зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс финтек зээлдэгчийн тоо 70.0 хувиар өсөн 2,637,111-д хүрч, зээлийн үлдэгдлийн хэмжээ 67.9% буюу 0.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цахим зээлийн мэдээлэл ирүүлэггүй 16 ББСБ-уудад холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр)

№	Финтек	App нэр	Бүртгүүлсэн огноо
1	Соно финтек	Sono Mongolia	2023.03.03 №7/895
2	Покет	Pocket.mn	2023.05.08 №7/1871
3	Тус финтек	Tus fintech	2023.05.19 №7/2125
4	Мобифинанс	Monpay	2023.06.20 №7/2540
5	Анлок капитал	Unlock Finance	2024.04.23 №7/1442
6	Лэндмн	LendMN	2023.06.20-№7/2550
7	Таван богд финанс	PayOn.mn	2023.07.04-№7/2826
8	Нөмөр кредит	Numur	2023.03.03-№7/890
9	Ашид капитал	Simple.mn	2023.11.10-№7/4317
10	ТОКИ	Toki	2023.06.20-№7/2549
11	Инвескор	InvesCore	2023.08.25-№7/3350
12	Нэт капитал финанс корпораци	NetPay	2023.07.04-№7/2825
13	Жи Эс Би капитал	Prime	2024.02.21-№7/631
14	Омни капитал	Moni	2023.07.05-№7/2869
15	Сэндли	Sendly	2023.07.04-№7/2821
16	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03-№7/894
17	Си И Си инвестмент	Pocket.mn	
18	Ньюстар финанс	Nsf.mn	2023.06.20-№7/2552
19	Бизнес-Инвест девелопмент	BiD	2023.08.25-№7/3353
20	Очир ундраа ОМЗ	Opay MN	2023.08.25-№7/3351
21	Навитас фанд	Pocket.mn	
22	Мөнгөнзоос кредит	Pocket.mn	
23	Зөгий санхүүгийн групп	Pocket.mn	2025.08.01-№7/2917
24	Кэйш флов финанс	Tugrug App	2024.02.21-№7/632
25	Цогзолфинанс	Pocket.mn	
26	Сэнд эм эн	SendMN	2024.02.21-№7/636
27	Энт кредит инвестмент	EntCreditMN	2023.03.03-№7/891
28	Грийн-Инвестмент	Gate.mn	2023.07.04-№7/2827
29	Хас хаан	XACXAAH	2023.06.20-№7/2551
30	Балансэд кредит	Balance	2024.12.04-№7/3981
31	Төвхөн ингүүмэл	Oneclick.mn	2024.07.09-№7/2534
32	Мэйн стрит финанс	Pays	2025.02.11-№3/425
33	Финко капитал	Beep	2024.09.23-№7/3172
34	Алтан зоос капитал	ZOOS	2024.05.30-№7/2046
35	Их Монгол кредит	Ikh Mongol Credit	2024.02.21-№7/633
36	Их ирээдүй капитал	Easy loan	2024.05.30-№7/2043
37	Жи би си си	E-zeel	2023.03.03-№7/889
38	Фингейт эм эн	M credit	
39	Девелопинг энтрепренюриал монголиа	DEM.mn	2024.05.30-№7/2045
40	Изи пэй норбула	Easypay.mn	2023.12.22-№7/4867
41	Инвеско фанд	IF.mn	2023.08.25-№7/3349
42	Хексинг финанс	Sign Finance	2024.12.04-№7/3980
43	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04-№7/2828
44	Нанокapитал	Nano Capital	2023.07.04-№7/2824
45	Өсөх ундарга финанс	Ufinance	2024.09.23-№7/3171
46	Монголиа импакт финанс	Qmoni	2023.08.25-№7/3356
47	Эм Эл Жи финанс Юү Би	ANDA	2024.07.09-№7/2536
48	Улаанбаатар кредит	Upay	2024.12.16-№7/4110
49	Хангууд финанс	Khanguud	2023.12.22-№7/4872
50	Тапапэй	Tapa	2024.09.24-№7/3174
51	Онч-Энх	Ugloo	2023.03.30-№7/1297
52	Дарь финанс	Money mate	2025.06.18-№7/2427
53	Магна профит энд инвестмэнт	Magna.mn	2024.02.21-№7/635
54	Монкор финанс	Cash pay	2024.07.09-№7/2535
55	Ард кредит	Ard	2023.12.22-№7/4873
56	Финрүүт-Инвесмент	Pocket.mn	
57	Соломон инвестмент	M credit	2023.11.10-№7/4319
58	Гэрэл финанс	Gerel	2023.05.08-№7/1872
59	Дэвжих нэхий	Money-T	2023.12.22-№7/4870
60	Вишнфанд	Вишнфанд	2024.12.04-№7/3982
61	Микро кредит	Easy	2023.12.22-№7/4871
62	Номин юнити	OmniWay	2024.02.21-№7/634
63	Үнэт кредит	Valu up	2025.04.30-№3/1598
64	БСБ финанс	BSB Finance	2025.02.11-№3/427
65	Говь финанс	CashOne	2023.08.25-№7/3354
66	Гоулдман инвестмент	Goldpay	2023.08.25-№7/3355

67 Гурван зуун жар финанс	Minu pay	2023.07.04-№7/2822
68 Есөн финанс	MetaLend	2023.08.25-№7/3352
69 Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30-№7/1298
70 ЛэндМН СМЭ	LendMN	2025.08.26-№7/3216
71 Мандал дижитал кредит	Car zeel	2025.09.03.-№7/3308
72 Монголиан юнайтед кредит	UniPay.mn	2024.12.04-№7/3979
73 Монголын санхүүгийн групп	Мост мони	
74 Прогресс финтек	Zuut	2024.05.30-№7/2044
75 Сагоши накамото	Cash24	2025.09.02-№7/3282
76 Франкфурт капитал	Nar app	2023.07.04-№7/2823
77 Централ капитал	Kmobimn	2024.04.23-№7/1441

/"Инвескор ББСБ" ХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 10 ББСБ байна.
Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 5 ББСБ-ыг шараар тэмдэглэв/

Ногоон зээл

Тайлант хугацаанд 37 ББСБ 10,398 зээлдэгчид 122.5 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.8 хувийн хүүтэйгээр олгож, 42 ББСБ-ын 9,207 зээлдэгчээс 75.4 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2025 оны III улирлын байдлаар 42 ББСБ 13,124 зээлдэгчийн 154.0 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.2%-тай тэнцэж байна.

Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)


	НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 12 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
		Дүн	Зээлдэгч- дийн тоо	Дүн	Зээлдэгч- дийн тоо	Дүн	Зээлдэгч- дийн тоо
Ногоон	1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	351.8	36	719.7	21.0	521.4	22
	2. Эрчим хүчний үр ашиг	21,989.8	7,457	6,499.0	4,326.0	24,999.9	7,640
	3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	11,500.4	170	14,637.9	405.0	23,142.4	1,106
	4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	3.0	1	114.8	2.0	15.5	7
	5. Тогтвортой ус, хог хаягдал	1,641.2	30	1,530.3	30.0	1,011.1	27
	6. Тогтвортой хөдөө аж, ахуй	11,630.5	369	3,755.8	426.0	8,845.7	420
	7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	1,754.8	72	861.7	98.0	6,263.0	321
	8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	51,022.3	1,807	37,039.2	3,455.0	63,683.2	2,943
	8.1.Цахилгаан тээврийн хэрэгсэл	7,554.8	88	3,918.2	156.0	8,836.3	142
	8.2.Хосолсон хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл	39,474.2	1,659	26,078.4	2,775.0	44,284.1	2,352
	8.3.Хэмнэлттэй тээврийн хэрэгсэл	1,158.5	11	837.4	464.0	9,111.3	339
	8.4.Дугуй, скүүтэр	0.0	0	0.7	0.0	3.1	2
8.5.Бусад	2,834.8	49	6,204.5	60.0	1,448.3	108	
Нийгэм	9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	2,376.0	34	909.3	47.0	1,469.1	54
	10. Эрүүл мэнд	12,329.0	194	2,080.8	136.0	11,244.5	252
	11. Боловсрол, Соёл	6,920.0	219	1,370.5	235.0	9,206.3	311
	12. Хүртээмжтэй дэд бүтэц	1,007.3	9	5,879.8	26.0	3,608.0	21
НИЙТ		122,526.2	10,398	75,398.7	9,207.0	154,010.0	13,124

Ногоон зээлийн үлдэгдлийн 41.3% буюу 63.7 тэрбум төгрөгийг нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээврийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 15.0% буюу 23.1 тэрбум төгрөгийг тогтвортой хот төлөвлөлт ба барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 16.2% буюу 25.0 тэрбум төгрөгийг эрчим хүчний үр ашиг салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 5.7% буюу 8.8 тэрбум төгрөгийг тогтвортой хөдөө аж, ахуй салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 7.3% буюу 11.2 тэрбум төгрөгийг эрүүл мэнд ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, болон 14.5% буюу 22.2 тэрбум төгрөгийг бусад ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ногоон санхүүжилт – Бүс нутгийн чуулган”-аар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, “Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх талаар хэлэлцэн, зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 1.3-т “Ногоон зээлийг банкны салбарт 10 хувь, ББСБ-уудад 5 хувьд хүргэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ногоон зээлд эрсдэлийн сан байгуулах, хөнгөлөлт урамшуулал олгох, ногоон зээлийн эх үүсвэрийн свопын зардлыг бууруулах зэрэг хөшүүрэг бий болгох” үүргийг


Санхүүгийн зохицуулах хороо хүлээсэн. Үүний дагуу 2022 оны 1 дүгээр улирлаас эхлэн “Монгол Улсын Ногоон таксономи”-ийн үндсэн ангиллын дагуу ББСБ-уудаас “Ногоон зээлийн тайлан”-г авч эхэлсэн. 2022 оны III улирлын байдлаар 78,332 сая төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй байсан бол, 2025 оны мөн улиралд ногоон зээлийн үлдэгдэл 2.0 дахин өсч 154,010.0 сая төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зураг 8 Сүүлийн 3 жилийн байдлаар ногоон зээлийн үлдэгдэл(тэрбум төгрөгөөр)



Нийт зээлийн үлдэгдлийн 90.4% буюу 139.2 тэрбум төгрөг нь хэвийн, 4.8% буюу 7.5 тэрбум төгрөг нь анхаарал хандуулах, 4.8% буюу 7.3 тэрбум төгрөг нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 9 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)



Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 349.9 хувиар буюу 64.5 тэрбум төгрөгөөр өсөж, 27 ББСБ 82.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2025 оны III улирлын байдлаар 918.1 сая төгрөгийн факторингийн тооцооны хүүгийн авлага хуримтлуулан бүртгэсэн байна. Нийт 15.5 тэрбум төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 5.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 77.4 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)

Нийт факторингийн тооцооны авлага	2024-III		2025-III		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь		
	18,418.7	100.0%	82,869.0	100.0%	64,450.2	349.9%
Хэвийн	16,529.7	89.7%	66,457.7	80.2%	49,928.0	302.0%
Анхаарал хандуулах	213.4	1.2%	5,375.2	6.5%	5,161.8	2418.7%
Чанаргүй	770.0	4.2%	10,118.0	12.2%	9,348.0	1214.1%
Хэвийн бус	314.3	1.7%	3,618.8	4.4%	3,304.4	1051.2%
Эргэлзээтэй	156.1	0.8%	4,418.0	5.3%	4,261.9	2730.2%
Муу	299.5	1.6%	2,081.2	2.5%	1,781.6	594.8%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	466.8	2.5%	5,463.6	6.6%	4,996.8	1070.4%
Факторингийн тооцооны хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	905.6	4.9%	918.1	1.1%	12.5	1.4%

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан ба факторингийн тусгай зөвшөөрөлтэй 60 ББСБ-уудаас 36 ББСБ нь тайлант хугацаанд факторингийн үйл ажиллагаа эрхлээгүй байгаа тул холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө

2025 оны III улирлын байдлаар 4 ББСБ 7.0 тэрбум төгрөгийн своп арилжаа хийсэн байна.

Бусад санхүүгийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 36.4 хувь буюу 64.8 тэрбум төгрөгөөр өсөж 243.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	6,965.6	6,965.6	3,404.7	3,560.9	-	6,965.6	-	151.4	151.4
Своп арилжаа	6,965.6	6,965.6	3,404.7	3,560.9	-	6,965.6	-	151.4	151.4
Бусад санхүүгийн хөрөнгө	243,062.8	174,211.4	66,231.4	176,831.4	100.0	238,348.2	4,714.6	48,234.9	20,629.6
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага	28,317.6	28,317.6	46.6	28,271.0	-	28,317.6	-	-	-
Авлага(цэвэр дүнгээр)	178,720.2	117,322.7	58,842.8	119,877.4	100.0	174,255.3	4,464.8	48,227.7	20,481.3
Салбар хоорондын тооцоо	26,638.3	26,506.9	22.8	26,615.5	-	26,638.3	-	-	-
Өмчлөх бусад хөрөнгө – санхүүгийн хөрөнгө (цэвэр дүнгээр)	2,435.2	914.3	2,370.5	64.7	-	2,435.2	-	-	71.5
Бусад	6,951.5	1,149.9	4,948.7	2,002.8	-	6,701.8	249.8	7.2	76.8

Санхүүгийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2025 оны III улирлын байдлаар 230.7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 66.6 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулж, 33.3 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэсэн байгаа бол 83.5 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлд 31.4 тэрбум төгрөгийн хорогдол байгуулсан байна.

Ингэснээр тайлант хугацаанд 164.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 52.1 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө (цэврээр)	164,054.6	110,295.9	72,638.6	91,415.9	465.9	160,891.1	3,163.5	16,216.8	15,285.3
Барилга, байгууламж	74,211.2	55,648.2	26,621.9	47,589.3	81.4	72,772.4	1,438.8	5,258.5	7,641.7
Компьютер, дагалдах хэрэгсэл	12,424.1	8,696.6	4,924.9	7,499.2	29.2	11,938.9	485.3	1,334.9	1,193.5
Тээврийн хэрэгсэл	44,430.0	20,658.6	29,480.5	14,949.5	282.8	43,595.4	834.6	1,484.3	2,032.3
Тавилга, эд хогшил	17,307.7	12,077.6	7,784.7	9,523.0	64.3	16,930.4	377.3	1,334.8	1,439.2
Түрээсийн хөрөнгө	11,908.1	10,533.4	2,803.1	9,105.1	-	11,898.9	9.2	5,932.4	2,756.0
Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	3,773.4	2,681.4	1,023.6	2,749.8	8.3	3,755.2	18.2	872.0	222.6
Биет бус хөрөнгө (цэврээр)	52,145.9	34,771.3	10,786.3	41,359.6	3.6	51,931.0	214.9	5,078.6	2,791.4
Зохиогчийн эрх	27.6	24.2	27.6	-	-	27.6	-	-	4.7
Програм хангамж	32,068.6	25,767.1	4,184.0	27,884.6	3.6	31,888.1	180.5	4,561.3	2,783.7
Мэдээллийн сан	-	-	-	-	-	-	-	-	-
Патент	995.3	1.5	995.3	-	-	995.3	-	-	-
Барааны тэмдэг	45.4	20.9	-	45.4	-	45.4	-	-	-
Тусгай зөвшөөрөл	19.7	-	-	19.7	-	19.7	-	-	-
Газар эзэмших эрх	1,478.8	1,341.0	1,400.0	78.8	-	1,466.0	12.9	-	-
Ашиглах эрхтэй хөрөнгө	7,221.7	6,787.0	1,370.2	5,851.5	-	7,209.7	12.0	231.2	-
Бусад биет бус хөрөнгө	10,288.7	829.7	2,809.2	7,479.5	-	10,279.2	9.5	286.1	3.0

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 41.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 58.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:


Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Пассивын үзүүлэлтүүд	2024-III	Нийт дүнд	2025-III	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,038,317.5	47.3%	3,921,608.4	46.0%	883,290.9	29.1%
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,866,470.3	44.7%	3,692,896.9	43.3%	826,426.6	28.8%
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,062,760.9	16.6%	1,293,271.6	15.2%	230,510.7	21.7%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,026,257.7	16.0%	1,445,010.0	16.9%	418,752.3	40.8%
Бусад эх үүсвэр	543,000.4	8.5%	709,866.7	8.3%	166,866.3	30.7%
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	1,151.6	0.0%	3,753.1	0.0%	2,601.4	225.9%
Бусад санхүүгийн өр төлбөр	232,876.9	3.6%	219,603.4	2.6%	-13,273.5	-5.7%
Хоёрдогч өглөг	422.9	0.0%	21,392.2	0.3%	20,969.3	4958.7%
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	-	-	-	-
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	171,847.2	2.7%	228,711.5	2.7%	56,864.3	33.1%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,379,280.8	52.7%	4,607,724.7	54.0%	1,228,443.9	36.4%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,714,924.3	26.7%	2,110,670.8	24.7%	395,746.4	23.1%
Нэмж төлөгдсөн капитал	85,716.8	1.3%	106,105.8	1.2%	20,388.9	23.8%
Халаасны хувьцаа	-2,580.2	0.0%	2,580.2	0.0%	5,160.4	-200.0%
Үндсэн хөрөнгө, биет бус ХДҮН	5,243.6	0.1%	22,510.7	0.3%	17,267.1	329.3%
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,501,679.6	23.4%	2,254,310.6	26.4%	752,631.0	50.1%
Бусад өмч	74,296.7	1.2%	116,707.2	1.4%	42,410.5	57.1%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,417,598.3	100.0%	8,529,333.1	100%	2,111,734.8	32.9%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.2 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.4 дахин, бусад эх үүсвэр 1.3 дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 3.3 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 0.9 дахин, барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 50.6 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 50.1 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 23.1 хувиар, нэмж төлөгдсөн капитал 23.8 хувиар тус тус өссөн байна. Мөн бусад өмчийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өссөнд хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөгийн үлдэгдэл болон итгэлцлийн үйл ажиллагааны нөөцийн сан хамгийн их нөлөөлж байна.


Салбарын сүүлийн 5 жилийн байдлаарх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2020 оны III улирлын байдлаар өөрийн хөрөнгө банкны салбарын 46.1 хувьд хүрдэг байсан бол 2025 оны III улирлын байдлаар 61.4 хувьд хүрч байна. 2025 оны III улирлын байдлаар 577 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 116.2 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 39.7 хувьтай тэнцдэг байсан бол 2025 оны III улирлын байдлаар 8.7 пунктээр өсөж 48.4 хувьтай тэнцэж байна.

Зураг 10 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2025 оны III улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2020 онтой харьцуулахад 3.3 дахин өсөж 4.6 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 7.0 дахин өсөж 3.9 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 11 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2025 оны III улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 1.2 дахин буюу 230.5 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 90 ББСБ-аас 86 ББСБ нь 14,688 итгэмжлэгчдээс 1,293.3 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 12 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)



Нийт татан төвлөрүүлсэн итгэлцлийн өглөгийн 69.1 хувийг иргэдээс, 25.6 хувийг хувийн байгууллагаас, 0.6 хувийг эдийн засгийн харьяат бус этгээдээс татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд 1,233.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж үүнд 60.7 тэрбум төгрөгийн үр шим хуримтлуулан тооцож бүртгэсэн байна.

Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)

	Дүн	Хувь	Итгэл-цэлтэй	Уламж-лалт	Финтек	УБ	ХОН	ХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,293,271.6	100.0%	1,291,059.5	226,752.0	1,066,519.6	-	1,285,905.5	7,366.1	288,127.9
Хувийн байгууллага	331,623.7	25.6%	331,273.7	66,327.5	265,296.2	-	327,356.7	4,267.0	46,370.0
Иргэд	893,603.7	69.1%	891,863.7	147,520.1	746,083.6	-	890,768.8	2,834.9	228,810.2
Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)	-	0.0%	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн харьяат бус	7,812.4	0.6%	7,812.4	2,399.6	5,412.8	-	7,812.4	-	-
Итгэлцлээр татсан хөрөнгөнд хуримтлуулагч тооцсон үр шим	60,659.4	4.7%	60,537.3	10,504.8	50,154.6	-	60,395.2	264.2	13,375.3
Итгэлцлээр татсан хөрөнгийн хойшлогдсон төлбөр	427.6	0.0%	427.6	-	427.6	-	427.6	-	427.6
Нийт итгэмжлэгчдийн тоо	14,688.0		14,681.0	1,482.0	13,206.0	-	14,629.0	59.0	6,560.0

Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

2025 оны III улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 дахин өсөж, 122 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 1,445.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,445,010.0	1,224,269.8	387,297.2	1,057,712.8	243.6	1,442,396.2	2,613.8	492,159.2	375,792.4
Авсан зээл	1,410,795.6	1,203,453.0	380,492.7	1,030,302.9	243.6	1,408,379.9	2,415.8	485,347.9	370,961.1
Дотоодын	575,893.1	445,901.2	137,263.0	438,630.1	243.6	573,867.3	2,025.8	163,951.6	137,988.0
Гадаадын	457,598.9	453,630.4	44,173.7	413,425.3	-	457,598.9	-	275,530.7	232,973.1
Бусад	377,467.9	304,085.6	199,056.1	178,411.8	-	377,077.9	390.0	45,865.6	-
Бодит үнэ цэнийн залруулга	164.2	164.2	-	164.2	-	164.2	-	-	-
Хугацаа хэтрэлт	1,976.3	1,698.0	1,698.0	278.3	-	1,778.3	198.0	-	-
Дотоодын	1,500.0	1,500.0	1,500.0	-	-	1,500.0	-	-	-
Гадаадын	278.3	-	-	278.3	-	278.3	-	-	-
Бусад	198.0	198.0	198.0	-	-	-	198.0	-	-
Бодит үнэ цэнийн залруулга									
Хойшлогдсон төлбөр	3,018.9	3,018.9	570.5	2,448.4	-	3,018.9	-	2,448.4	2,395.6
Дотоодын	52.8	52.8	-	52.8	-	52.8	-	52.8	-
Гадаадын	2,966.1	2,966.1	570.5	2,395.6	-	2,966.1	-	2,395.6	2,395.6
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Хуримтлуулагч тооцсон хүүгийн өглөг	35,257.0	22,137.8	5,677.0	29,580.0	-	35,257.0	-	9,259.6	7,226.9
Дотоодын	16,672.2	4,677.5	574.0	16,098.2	-	16,672.2	-	1,267.5	1,264.4
Гадаадын	10,228.2	10,150.0	950.8	9,277.4	-	10,228.2	-	6,908.8	5,962.5
Бусад	8,356.6	7,310.2	4,152.2	4,204.5	-	8,356.6	-	1,083.3	-

Бусад эх үүсвэр

2025 оны III улирлын байдлаар 75 ББСБ 709.9 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс давхардсан тоогоор 62 ББСБ 626.1 тэрбум төгрөгийн өрийн бичиг, 2 ББСБ 41.4 тэрбум төгрөгийн үнэт цаас, 4 ББСБ төслийн зээл, 18 ББСБ 18.7 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэр, 3 ББСБ 869.8 сая төгрөгийн хойшлогдсон төлбөр, 59 ББСБ 24.1 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл- тэй	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Бусад эх үүсвэр	709,866.7	651,265.6	117,633.4	592,233.3	-	709,804.3	62.4	116,752.9	59,441.5
Гаргасан өрийн бичиг	626,135.1	573,334.3	108,095.8	518,039.3	-	626,135.1	-	106,420.5	58,400.0
Гаргасан үнэт цаас	41,371.1	41,371.1	-	41,371.1	-	41,371.1	-	-	-
Төслийн зээлийн санхүүжилт	418.8	36.8	305.3	113.6	-	418.8	-	-	-
Бусад	18,710.9	17,469.3	3,174.8	15,536.1	-	18,650.9	60.0	8,763.1	68.5
Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	869.8	869.8	-	869.8	-	869.8	-	763.6	557.2
Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	24,100.6	19,923.9	6,057.5	18,043.1	-	24,098.2	2.4	2,332.9	1,530.2

ББСБ-аас гаргасан өрийн бичиг

ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах үүрэгтэй.


2025 оны III улирлын байдлаар биржийн бус зах зээл дээр 61 ББСБ 578,609.2 сая төгрөг татан төвлөрүүлсэн тухай тоо мэдээ ирүүлсэн байна. Үүнийг санхүүгийн тайланд тусгасан тоо мэдээтэй тулган баталгаажуулахад нэр бүхий 1 ББСБ огт бүртгэлгүй санхүүгийн тайланд 2.8 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэл тусгасан байгаа тул журам зөрчсөн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Биржийн бус зах зээлийн тоо мэдээнээс санхүүгийн тайланд тайлагнасан дүн зөрсөн 8 ББСБ-ын 8.8 тэрбум төгрөгийн зөрүүтэй байгаагаас 1 ББСБ нь 1.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн бөгөөд үүнийг санхүүгийн тайлагналдаа тусгаагүйгээс гадна үлдсэн 7 ББСБ 7.4 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан байна.

Биржийн зах зээл дээр 2025 оны III улирлын байдлаар 4 ББСБ 53.5 тэрбум төгрөгийг бондыг татан төвлөрүүлсэн байна.

62 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд 626.1 тэрбум төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй гарсан байгаа нь 2020 оны мөн үеэс 10.2 дахин өссөн үзүүлэлт юм.


Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 4 ББСБ 418.8 сая төгрөгийг татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төслийн зээлийн санхүүжилт 2020 оны мөн үеэс 17.1 тэрбум төгрөг буюу 5.1 дахин, өмнөх оны мөн үеэс 15.6 тэрбум төгрөг буюу 4.7 дахин буурсан байна.

Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар



Төслийн зээлийн санхүүжилтийг олгосон субъектээр нь ангилж харвал 3.7 хувь нь гадаадын төслийн, 96.3 хувь нь дотоодын санхүүжилттэй төслийн санхүүжилтийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Төслийн зээлийн санхүүжилт	418.8	36.8	305.3	113.6	-	418.8	-	-	-
Засгийн газрын санхүүжилттэй	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын санхүүжилттэй	15.6	-	-	15.6	-	15.6	-	-	-
Дотоодын санхүүжилттэй	403.2	36.8	305.3	98.0	-	403.2	-	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн санхүүжилтийн зээл	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Зах зээлийн хүүгийн түвшнээс өндөр буюу бага хүү бүхий зээлийн бодит үнэ цэнийн тохируулга	-	-	-	-	-	-	-	-	-

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)

2025 оны III улирлын байдлаар ББСБ-уудын гаргасан ХБҮЦ-ыг харвал 18-24 сарын хугацаатай, жилийн 17.0-20.0 хувийн хүүтэй, 6.0-50.0 тэрбум төгрөгийн буюу нийт 264 тэрбум төгрөгийн 8 ББСБ-ийн нээлттэй зах зээлд гаргасан ХБҮЦ байна.

Бусад санхүүгийн өр төлбөр

2025 оны III улирлын байдлаар 3 ББСБ 3.58 тэрбум төгрөгийн үүсмэл санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 97 ББСБ 229.5 тэрбум төгрөгийн бусад санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 7 ББСБ 21.4 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	3,753.1	3,753.1	244.9	3,508.2	-	3,753.1	-	98.6	98.6
Форвард арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Своп арилжаа	3,753.1	3,753.1	244.9	3,508.2	-	3,753.1	-	98.6	98.6
Опшин арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Фьючерс арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	219,603.4	206,035.9	22,862.6	196,740.8	520.5	219,079.8	523.6	52,641.1	35,913.9
Хоёрдогч өглөг	21,392.2	2,325.6	75.7	21,316.5	-	21,392.2	-	298.4	-
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн бус өр төлбөр

Санхүүгийн бус өр төлбөрийн 55.7 хувийг бусад өр төлбөр, 27.8 хувийг тайлант үеийн орлогын албан татварын өглөг, 10.9 хувийг бусад татварын өглөг, 1.3 хувийг урьдчилж орсон орлого, 1.6 хувийг цалингийн өглөг, 2.6 хувийг бусад өглөг бүрдүүлж байна.

Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр)

САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
	228,711.5	139,113.1	98,541.0	130,170.5	201.1	225,277.7	3,433.7	23,491.7	7,661.3
Цалингийн өглөг	3,585.6	2,680.6	920.4	2,665.2	32.9	3,548.7	37.0	616.9	599.5
ЭМ, НДШ-ийн өглөг	1,749.2	671.2	983.0	766.2	27.4	1,684.4	64.8	258.7	323.7
Тайлант үеийн орлогын албан татварын өглөг	63,695.4	46,969.5	19,037.5	44,657.9	43.1	63,050.6	644.8	8,373.0	633.2
Бусад татварын өглөг	25,011.4	20,694.2	7,060.0	17,951.4	94.5	24,869.5	141.9	2,665.2	2,520.8
Хойшлогдсон татварын өглөг	2,041.1	1,841.4	1,452.1	589.0	-	2,007.2	33.9	300.0	40.9
Хойшлогдсон орлого	2,168.9	2,148.8	1,824.5	344.4	-	2,168.9	-	-	-
Урьдчилж орсон орлого	3,067.7	744.7	2,791.9	275.8	-	3,061.1	6.6	156.1	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр	53.8	48.7	53.8	-	-	53.8	-	-	-
Бусад	127,298.6	63,275.8	64,379.4	62,919.2	3.2	124,793.8	2,504.8	11,121.8	3,543.1
Нооц, болзошгүй өр төлбөр	39.8	38.2	38.3	1.4	-	39.8	-	-	-

Өөрийн хөрөнгө

ББСБ-уудын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 36.4 хувиар буюу 1,228.4 тэрбум төгрөгөөр өсөж 4.6 их наяд төгрөгт хүрсэн нь нийт активын 54.0 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын өөрийн хөрөнгийн 45.8 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 48.9 хувийг хуримтлагдсан ашиг, 5.3 хувийг өөрийн хөрөнгийн бусад хэсэг бүрдүүлж байна.

Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,110.7	957.6	1,260.1	850.6	26.2	2,043.3	67.4	59.4	147.5
Нэмж төлөгдсөн капитал	106.1	105.6	18.6	87.5	0.1	105.9	0.2	68.4	48.8
Халаасны хувьцаа	2.6	2.6	0.2	2.4	-	2.6	-	2.4	0.0
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22.5	13.9	1.3	21.2	-	22.4	0.1	-	0.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	2,254.3	1,618.7	920.4	1,334.0	10.1	2,212.3	42.0	260.6	175.0
Бусад өмч	116.7	111.7	12.8	103.9	0.0	115.2	1.5	26.9	7.6
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,607.7	2,804.9	2,212.9	2,394.8	36.4	4,496.5	111.2	413.0	378.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,529.3	6,322.7	3,066.3	5,463.0	37.4	8,404.1	125.2	1,386.5	1,027.1
Нийт хөрөнгөд эзлэх хувь	54.0%	44.4%	72.2%	43.8%	97.4%	53.5%	88.8%	29.8%	36.9%

Хувь нийлүүлсэн хөрөнгө


Хувь нийлүүлсэн хөрөнгө нь өмнөх оны мөн үеэс 23.1 хувь буюу 395.8 тэрбум төгрөгөөр өсөж 2.1 их наяд төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,110,670.8	957,631.5	1,260,065.8	850,604.9	26,202.0	2,043,280.2	67,390.6	59,435.7	147,469.7
Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө)	150,678.3	150,000.0	678.3	150,000.0	-	150,636.0	42.3	12,000.0	12,121.0
Энгийн хувьцаа - Хаалттай	1,912,556.8	760,195.9	1,253,347.5	659,209.3	26,202.0	1,845,208.5	67,348.3	-	112,114.7
Энгийн хувьцаа - Нээлттэй	47,435.7	47,435.7	6,040.0	41,395.7	-	47,435.7	-	47,435.7	23,234.0
Хоёрдогч өглөг (өөрийн хөрөнгө)	76,719.3	73,609.3	2,915.0	73,804.3	-	76,719.3	-	17,604.3	-
Хөрвөх өр төлбөр (өөрийн хөрөнгө)	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	106,105.8	105,561.3	18,566.4	87,539.4	68.8	105,910.1	195.7	68,422.4	48,820.1
Давуу эрхийн хувьцаа	191.7	-	191.7	-	-	69.0	122.7	-	-
Энгийн хувьцаа	105,914.1	105,561.3	18,374.7	87,539.4	68.8	105,841.1	73.0	68,422.4	48,820.1
Халаасны хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6
Давуу эрхийн хувьцаа	-	-	-	-	-	-	-	-	-
Энгийн хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6

2025 оны III улирлын байдлаар 577 ББСБ-ын 2.0 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 9 ББСБ-ын 105.7 тэрбум төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.6 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 15 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ 2.0 их наяд төгрөг байгаа нь нийт өөрийн хөрөнгийн 42.8 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 2.6 их наяд төгрөг байгаа нь нийт дүнгийн 78.0 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын үйл ажиллагаа өргөжиж, томрохын хэрээр бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэх боломж нь нэмэгдэж байгаа тул эдгээр ББСБ-уудын зайны болон газар дээрх хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сүмд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,101.5	90	52.2%	15.6%	7.3	1	6.9	1	0.0	0
2.5-5.0 тэрбум	940.5	336	44.6%	58.2%	5.8	2	5.0	2	0.0	0
1.9-2.5 тэрбум	3.9	2	0.2%	0.3%	0.0	0	0.0	0	3.9	2
1.4-1.9 тэрбум	9.0	6	0.4%	1.0%	1.5	1	6.1	4	1.4	1
0.6-1.4 тэрбум	22.1	25	1.0%	4.3%	11.7	14	6.5	7	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	33.7	118	1.6%	20.5%	0.0	0	16.6	65	18.0	57
НИЙТ	2,110.7	577	100.0%	100.0%	26.2	18	41.2	79	26.2	63

2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 426 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 96.8% буюу 2.0 их наяд төгрөг байна. Харин 2.5 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 151 ББСБ-ын 68.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.2 хувийг бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгийн бусад хэсэг

2025 оны III улирлын байдлаар 35 ББСБ 22.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 110 ББСБ 116.7 тэрбум төгрөгийн бусад өмчийн үлдэгдэлтэй гарчээ.


Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22,510.7	13,926.4	1,321.6	21,189.1	-	22,377.0	133.7	-	6.5
Бусад өмч	116,707.2	111,688.1	12,781.4	103,925.8	0.0	115,232.2	1,474.9	26,851.4	7,551.8

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 50.1% буюу 752.6 тэрбум төгрөгөөр өсөж 2.3 их наяд төгрөгт хүрчээ.


Зураг 16 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд 497 ББСБ нийт 722.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 13 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 67 ББСБ 5.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажилласан 67 ББСБ дотор эх үүсвэр татан төвлөрүүлсэн 10 ББСБ байна. Эдгээрийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг яаралтай хийж гүйцэтгэх шаардлагатай.


Зураг 17 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Ашигт ажиллагаа

2025 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 1,941.1 тэрбум төгрөгийн орлого олж, 1,223.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 717.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 18 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 51.3% буюу 658.5 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 56.2% буюу 440.3 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 43.7% буюу 218.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)

Орлого, зардлын зүйл	2024-III	2025-III	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
НИЙТ ОРЛОГО	1,282,617.9	1,941,144.6	100.0%	658,526.7	51.3%
Хүүгийн орлого	1,117,034.7	1,716,238.4	88.4%	599,203.7	53.6%
Хүүгийн бус орлого	143,644.2	178,556.0	9.2%	34,911.8	24.3%
Бусад орлого, олз	22,971.5	46,072.8	2.4%	23,101.3	100.6%
Бусад дэлгэрэнгүй орлого	-	277.4	0.0%	277.4	0.0%
НИЙТ ЗАРДАЛ	783,286.3	1,223,615.9	100.0%	440,329.6	56.2%
Хүүгийн зардал	273,290.5	455,778.7	37.2%	182,488.2	66.8%
Хүүгийн бус зардал	322,846.7	399,853.1	32.7%	77,006.5	23.9%
Эрсдэлийн сангийн зардал	85,869.5	208,257.3	17.0%	122,387.8	142.5%
Бусад зардал, гарз	12,002.9	15,385.9	1.3%	3,382.9	28.2%
Орлогын албан татварын зардал	89,276.7	144,340.9	11.8%	55,064.2	61.7%
ЦЭВЭР АШИГ	499,331.7	717,528.7		218,197.0	43.7%

Нийт орлогын 88.4 хувийг хүүгийн орлого, нийт зардлын 37.2 хувийг хүүгийн зардал, 32.7 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Хүүгийн бус зардлын 88.1 хувийг үйл ажиллагааны бусад зардал бүрдүүлж байгаа бөгөөд үүний 49.5 хувийг ажилтнуудын цалинтай холбоотой зардал бүрдүүлж байна.

Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
НИЙТ ОРЛОГО	1,941.1	1,514.2	573.9	1,367.2	4.0	1,914.6	26.5	320.0	196.5
Хүүгийн орлого	1,716.2	1,373.4	490.1	1,226.2	0.1	1,692.3	23.9	288.6	181.9
Хүүгийн бус орлого	178.6	108.2	60.2	118.3	3.9	176.1	2.4	18.1	5.0
Бусад орлого, олз	46.1	32.7	23.3	22.7	-	45.9	0.2	13.3	9.6
Бусад дэлгэрэнгүй орлого	0.3	(0.1)	0.3	(0.0)	-	0.3	-	-	(0.1)
НИЙТ ЗАРДАЛ	1,223.6	994.2	321.5	902.1	2.1	1,209.9	13.8	249.6	154.2
Хүүгийн зардал	455.8	417.5	98.0	357.8	-	454.4	1.4	115.5	75.4
Хүүгийн бус зардал	399.9	280.5	132.2	267.6	2.0	392.0	7.8	49.5	30.8
Арилжааны зардал	2.9	2.3	0.8	2.0	-	2.9	0.0	0.2	0.1
Хани, үнэлгээний тэгшитгэлийн зардал	24.3	21.9	6.0	18.3	0.1	24.3	0.0	5.0	0.2
Хураамж, шимтгэлийн зардал	20.3	18.4	2.7	17.5	0.3	20.2	0.1	2.2	0.3
Үйл ажиллагааны бусад зардал	352.5	238.0	122.7	229.8	1.6	344.7	7.7	42.0	30.2
Эрсдэлийн сангийн зардал	208.3	165.1	48.4	159.9	-	205.1	3.1	64.6	38.6
Бусад зардал, гарз	15.4	10.7	5.5	9.8	0.0	15.0	0.4	2.1	1.3
ОАТ-ын зардал	144.3	120.3	37.4	107.0	0.1	143.3	1.1	17.9	8.1
НИЙТ ЦЭВЭР ОРЛОГО	717.5	520.1	252.4	465.1	1.9	704.7	12.8	70.4	42.2

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2025 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 577 ББСБ-ын 85.8% буюу 495 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 14.2 хувь нь буюу 82 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 76 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 6 ББСБ байна.

Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр)

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /90 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /424 ББСБ/		ЗГВА /63 ББСБ/		Нийт /577 ББСБ/	
		√	X	√	X	√	X	√	X
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	90	-	424	-	63	-	577	-
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	90	-	424	-	63	-	577	-
3.	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	90	-	424	-	63	-	577	-
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	86	4	414	10	63	-	563	14
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	88	2	394	30	63	-	545	32
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	89	1	419	5			571	6
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	90	-	424	-			577	-
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	90	-	422	2			575	2
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	90	-	420	4			573	4
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	90	-	424	-	XXX		577	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	90	-	424	-			577	-
12.	Монголын хөрөнгийн биржийн “I”, “III” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	90	-	424	-			577	-
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	90	-	424	-			577	-
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	90	-	423	1			576	1
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	90	-	418	6			571	6
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	89	1	XXX				576	1
17.	Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан	86	4	423	1			572	5
18.	Өрийн бичгийн зохистой харьцаа	84	6	421	3			568	9
19.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	89	1	418	6	62	1	569	8

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо, X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 32 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, өрийн бичгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.


Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан нэр бүхий 4 ББСБ-д холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Итгэлцэл, гадаад валютын арилжааны ББСБ-аас бусад 1 ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний нөөц сангийн харилцаа алдагдсан байгаа ба нэр бүхий ББСБ-ийн итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2025.02.25-ны өдрийн 28 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна.

Өгөөжийн үзүүлэлтүүд

2025 оны III улирлын байдлаар салбарын нийт хөрөнгийн өгөөж 9.6 хувь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 пунктээр, харин өөрийн хөрөнгийн өгөөж 18.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 пунктээр өссөн байна.

Зураг 19 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр



Гадаад валютын арилжааны мэдээ

Тайлант хугацаанд буюу 2025 оны III улиралд гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 169 ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээгээр 5.2 их наяд төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбарын 26.1 хувьтай, 5.4 их наяд төгрөгийн валют зарсан нь банкны салбарын 27.9 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 37 2025 оны III улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр)

	Нийт дүн		Авсан		Зарсан		Авсан		Зарсан	
	Авсан	Зарсан	I улирал	I улирал	II улирал	II улирал	III улирал	III улирал	III улирал	III улирал
Нийт дүн	5,202,186.6	5,371,942.6	1,577,986.6	1,766,645.8	1,842,061.2	1,824,144.3	1,782,138.8	1,781,152.5		
АНУ доллар	2,688,300.6	2,915,475.8	817,969.5	1,062,963.6	951,399.5	928,010.9	918,931.6	924,501.3		
Евро	233,457.0	229,014.6	51,851.1	52,367.4	87,640.9	85,442.0	93,965.0	91,205.2		
Японы иен	69,191.3	65,795.5	24,875.2	23,367.8	18,863.4	17,365.0	25,452.7	25,062.7		
Швейцар франк	14,458.1	14,338.7	4,776.2	4,723.3	4,993.3	4,961.2	4,688.6	4,654.2		
Шведийн крон	65.1	46.3	10.9	7.7	21.7	20.3	32.5	18.3		
Английн фунт	1,909.5	1,716.1	374.2	439.4	456.2	439.3	1,079.1	837.4		
Энэтхэгийн рупи	8.8	9.0	-	-	8.8	9.0	-	-		
Хонгконг доллар	5,662.9	5,960.3	2,094.2	2,297.1	1,956.7	2,133.6	1,612.0	1,529.6		
ОХУ-ын рубль	643,687.4	570,059.2	233,550.5	170,542.3	213,011.6	210,168.3	197,125.3	189,348.6		
Казахстан тэнгэ	60.7	56.0	1.7	-	27.1	19.6	31.9	36.4		
БНХАУ-ын юань	1,430,335.3	1,441,413.4	413,604.1	418,526.2	521,843.2	529,075.3	494,888.0	493,811.9		
БНСУ-ын вон	106,586.4	109,970.9	27,541.6	27,554.7	38,627.1	38,168.0	40,417.7	44,248.2		
Канадын доллар	612.6	548.3	68.0	78.5	200.9	192.8	343.7	277.0		
Австралийн доллар	4,000.9	3,814.6	707.6	680.7	1,879.4	1,821.7	1,413.9	1,312.2		
Чех крон	12.1	18.2	-	-	11.8	5.7	0.3	12.5		
Тайван доллар	1.1	0.0	-	-	1.1	-	-	-		
Тайланд бат	137.5	165.5	103.2	124.5	13.1	11.7	21.2	29.3		
Сингапур доллар	1,504.4	9,272.6	398.9	2,972.8	1,105.5	6,299.8	-	-		
Малайзын ринггит	1.7	0.0	1.7	-	-	-	-	-		
БНАСАУ-ын вон	2,193.3	4,267.9	58.1	-	-	-	2,135.2	4,267.9		

Дүгнэлт

2025 оны III улирлын тайлан мэдээний ирц 97.1% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 577 ББСБ-аас 560 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 11 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2025 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 38,583 хувьцаа эзэмшигчдийн 577 ББСБ, 570 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,519 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.6 сая харилцагч, 2.8 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар өсөж, банкны салбарын 11.0%-тай тэнцэж байна. банкны салбарын 11.3%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 116.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.8 пунктээр өссөн дүн юм.

2025 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 8.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.9 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 83.8 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн жилүүдэд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /160 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 34.6 хувь буюу 1.9 их наяд төгрөгөөр өсөж 2025 оны III улирлын байдлаар 7.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 408.3 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 6.9 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зээлийн багцын 86.4 хувийг буюу 6.0 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.7 хувийг буюу 327.4 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.9 хувийг буюу 621.6 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хэмжээ 2.7 пунктээр анхаарал хандуулах зээл 1.0 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 949.0 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 43.0 хувьд буюу 408.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 77 ББСБ 72 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна. 2025 оны III улирлын байдлаар ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 2.6 сая зээлдэгчийн 2.1 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 93.2 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 30.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 792.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 32.0 дахин бага байна. Цахим зээлийн мэдээлэл ирүүлээгүй 16 ББСБ-уудад холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 41.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 58.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.2 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.4 дахин, бусад эх үүсвэр 1.3 дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 3.3 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 0.9 дахин, барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 50.6 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс

хуримтлагдсан ашиг 50.1 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 23.1 хувиар, нэмж төлөгдсөн капитал 23.8 хувиар тус тус өссөн байна. Мөн бусад өмчийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өссөнд хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөгийн үлдэгдэл болон итгэлцлийн үйл ажиллагааны нөөцийн сан хамгийн их нөлөөлж байна.

Ашигт ажиллагаа

2025 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 1,941.1 тэрбум төгрөгийн орлого олж, 1,223.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 717.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 51.3% буюу 658.3 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 56.2% буюу 440.3 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 43.7% буюу 218.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2025 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 577 ББСБ-ын 85.8% буюу 495 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 14.2 хувь нь буюу 82 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 76 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 6 ББСБ байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 32 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, өрийн бичгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР